

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН УУЛ, УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМТАЙ БАЙГУУЛСАН
ДУНД ХУГАЦААНЫ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН 2017-2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ**

2020 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Багануур дүүрэг

Гэрээний заалт	Гэрээгээр хүлээсэн үүрэг	2017-2020 оны гүйцэтгэл
3.1.а.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн засаг дарга болон паркийн удирдлагын хамтран баталсан “Паркийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” 1-р улиралд багтаан баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;	Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны Сайдтай “Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын даргын 4 жилийн хугацаатай байгуулсан гэрээний дагуу Паркийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017 онд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон НЗД, БҮТП-ийн дарга нар баталж хэрэгжүүлсэн. 2018-2020 онуудад үйл ажиллагааны төлөвлөгөө УУХҮЯ болон НЗДТГ-ын зүгээс шаардлагагүй гэж үзээд УУХҮЯ-ны сайдтай байгуулсан гэрээний тайланг жил бүр хүргүүлж, мөн НЗД-тай байгуулсан үр дүнгийн гэрээг жил бүр тайлагнан ажилласан.
3.1.б.	Паркийг хөгжүүлэх хөтөлбөрийн /хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасан/ хэрэгжилтийг хангах болон паркийг хөгжүүлэх санг /хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д заасан/ байгуулахад орон нутгийн Иргэдийн хурал болон Засаг даргын тамгын газартай хамтран ажиллах;	<ul style="list-style-type: none"> ➢ 2019 онд Паркийн хөгжлийн Стратеги төлөвлөгөөг Багануур дүүргийн Засаг даргад танилцуулан дүүргийн нутаг дэвсгэрт Паркийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан ЖДҮ болон өрхийн үйлдвэрлэлийг дэмжих хамтарсан төлөвлөгөө батлан ажилласан. ➢ Багануур дүүргийн Засаг даргын зүгээс Паркийн үйл ажиллагааг дараах чиглэлд дэмжин ажиллах төлөвлөгөө амжилттай хэрэгжиж байна. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Паркийн хөрөнгө оруулалтын асуудлыг НИТХ-д хэлэлцүүлэх 2. Паркийн бүтээн байгуулалттай холбоотой асуудлаар Дүүргийн дэд бүтцийн мэргэжлийн байгууллагуудад хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх 3. Паркаас дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх ➢ 2019 онд Парк хөгжүүлэх орон нутгийн сан байгуулах саналыг дүүргийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт тавьсан боловч Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахыг хүлээн, шийдвэр гаргах боломжгүй гэдгээ мэдэгдээд байна. ➢ “Парк хөгжүүлэх сан” байгуулах төслийг дүүргийн ИТХ-д танилцуулсан. ИТХ-ын зүгээс ҮТП-ийн үндсэн үйл ажиллагааг эхлүүлэх, ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найрууллага батлагдах зэрэг үйл ажиллагааг хүлээж шийдвэрлээгүй байна.
3.1.в.	Паркийн техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж,	Тус паркийн ТЭЗҮ-ийг 2013 онд гүйцэтгэсэн “Мэргэшсэн инженерүүдийн нийгэмлэг” ТББ-ын удирдлагатай уулзалт зохион байгуулж, Паркийн нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах талаар хэлэлцэж санал солилцсон. Уг уулзалтаар тус нийгэмлэг ТЭЗҮ-ийг

	<p>яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх;</p>	<p>шинэчлэн боловсруулах хөрөнгөний асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулахад бэлэн байгаага илэрхийлсэн. /60,0 сая төгрөг/ Дээрх санхүүжилтийн асуудлыг УУХҮЯ болон нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст танилцуулсан боловч одоогоор шийдвэртэй хариу өгөөгүй байна.</p>
<p>3.1.г.</p>	<p>Паркийн Ерөнхий төлөвлөгөө болон инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах;</p>	<p>БҮТП-ийн ХЕТ болон инженерийн шугам сүлжээний иж бүрэн зураг төсөл боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийн БХБЯ-ны сайд 2017 онд шийдвэрлэж өгсөн. БХБЯ-наас зарласан сонгон шалгаруулалтаар Мон-Энержи Консалт ХХК шалгарч ерөнхий захиалагчтай 2018.01.11-ний өдрийн №2018/10 тоот гэрээ байгуулж, Паркийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж 2018.09.27-нд дуусах байсан боловч хугацааг 2 удаа сунгаж хойшлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ➢ НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. ➢ Гадна инженерийн шугам сүлжээний /ГИШС/ зураг төсөлд: “цахилгаан-эрчим хүч”-ний хэсгийн гүйцэтгэлийн ажил дараах 2 шалтгаанаар 2018-2019 онд зогссон байсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ ЭХЯ-наас Паркийн хэрэгцээнд шаардлагатай 63 МВт эрчим хүчээр 2024 он хүртэл хангах боломжгүй гэж үзээд техникийн нөхцөл олгоогүй. ○ “Мон-Энержи Консалт” ХХК нь нийт “эрчим хүчний ачааллын горимын тооцоо” /ЭХАГТ/-г Эрчим хүчний яамны “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иар гүйцэтгүүлэх ажил гэрээнд тусгагдаагүй гэсэн шалтгаан зааж, зардалыг шийдвэрлэх боломжгүй тухайгаа БХБЯ-д мэдэгдэж, тус яамнаас манайд энэ тухай мэдээлсэн. ➢ Манай зүгээс төслийн ажлыг үргэлжлүүлэн бүрэн гүйцэтгүүлэх шаардлага тулгарсан учраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв: Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ ЭХЯ-ны сайд болон сайдын зөвлөхтэй биечлэн уулзаж: 63МВт эрчим хүчний хэрэглээг 2024 он хүртэл авахгүй, харин БҮТП-ийн ХЕТ болон ГИШС-ий зураг төслийг гүйцэтгүүлэхэд техникийн нөхцөл шаардлагатай гэдгийг хэлэлцүүлж, улмаар тус яамны Техникийн зөвлөлийн хурлаар БҮТП-ийн иж бүрэн танилцуулга хийж шаардлагатай техникийн нөхцөлийг олгохоор шийдвэрлүүлсэн. ○ Мон-энержи консалт ХХК-ийн удирдлагатай биечлэн уулзаж, ДҮТ ХХК-иар хийлгэх ёстой ЭХАГТ-ний төлбөрийг байгууллагын үйл ажиллагааны төсвөөс шийдвэрлэж өгөх гэрээ байгуулснаар тус компаниас урьдчилан 16800 мянган төгрөг төлснөөр ЭХАГТ-г гүйцэтгүүлэн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02/16 дугаартай албан бичгээр хүлээн авч БХБЯ болон Мон-энержи консалти ХХК-д хүлээлгэн өгөв. ○ Ингэснээр цахилгаан хангамжийн төлөвлөлтийн зураг төсөл үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжоор бүрэн хангаж өгсөн.

		<ul style="list-style-type: none">○ 2024 он хүртэл БҮТП-ийн төслийн ажлуудыг тасралтгүй явуулах, эхний ээлжийн үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангах шаардлага зүй ёсоор гарсан учраас ЭХЯ болон ЦДҮС ТӨХК-тай уулзалт зохион байгуулж дээрх хэрэгцээ шаардлагыг хэлэлцүүлж, улмаар Багануур-220 дэд станцаас 110 кВ-ын шугамаар 8000 кВА эрчим хүчийг эхний ээлжинд авч болох боломжийг бүрдүүлсэн.○ Тайлант оны турш зураг төслийн ажлыг гүйцэтгүүлэхэд хамтарч ажиллахын зэрэгцээ дэд бүтцийн бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг олон гарцуудаар шийдвэрлүүлэхээр ажилласан. Үүний үр дүнд: Багануурт арматур төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа “МЕСЕС” ХХК нь 17 МВт эрчим хүч үйлдвэртээ татах техникийн нөхцөл авсан боловч трасс газаргүй тул БҮТП-ийн батлагдсан трассыг ашиглан хамтран хөрөнгө оруулалтаар дээрх 7,3 км ӨХАШ-ыг барих санал манайд тавьсан.➤ Тус үйлдвэрийн байршил манай паркийн Хөнгөн болон Хүнсний үйлдвэрийн бүстэй зэргэлдээ байршилтай байгаа учир тус компанийн саналыг нарийвчлан судалж үзсэний дүнд харилцан ашигтай байдлыг үндэслэн НЗД асан С.Амарсайхан болон Багануур дүүргийн засаг дарга асан Ц.Сандаг-очир нарт танилцуулж үүрэг чиглэл авч өнөөдрийг хүртэл ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<ul style="list-style-type: none">○ “МЕСЕС” ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Хамтран ажиллах гэрээ байгуулав.○ Талуудын цахилгаан эрчим хүч ашиглах Техникийн нөхцөлүүдийг нэгтгэх төслийг боловсруулан ЦДҮС ТӨХК-д хандаж, 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр мэргэжлийн зөвлөмж гаргуулав. Уг зөвлөмжийг үндэслэн ЭХЯ-ны Диспетчерийн үндэсний төвд хандаж, горимын тооцоо хийлгэж 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр дүгнэлт гаргуулав.○ БХБЯ-ны захиалгаар “Мон – Энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын цахилгаанаас бусад хэсгийг иж бүрэн дуусгаж, Барилгын хөгжлийн төвийн 2020.07.07-ны өдөр 1193/2020 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт гарч баталгаажсан.○ БҮТП-ийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэн ЭХЯ-нд 2020 оны 07 дугаар сарын 01-нд цахим системээр 20-99-000926 дугаартай хүсэлт болон 128 тоот дугаартай албан бичгийг хүргүүлсэнээр ЭХЯ-наас 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдөр “БҮТП болон Төмрийн үйлдвэрийн эрчим хүчний нэгдсэн ерөнхий цахилгаан хангамж”-ын №51/2020/87 дугаартай техникийн нөхцөл олгосон.○ 09 дүгээр сарын 16-ны өдөр ЭХЯ-наас “Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах №2020/Ц-61 дугаартай даалгавар” олгогдсон.○ Дээрх 2 баримтын дагуу ЦДӨХАШ-ын урьдчилсан трассын шугамын зургийг боловсруулж, ЦДҮС ТӨХК-аар баталгаажуулахаар хүргүүлсэн.
--	--	---

		<ul style="list-style-type: none"> ➤ 7,3 км ЦДӨХАШ-ыг байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын 50% болох 2,75 тэрбум төгрөг болон 110/35/10 кВт-ын дэд станц байгуулах 5,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төслийг Нийслэл болон улсын төсөвт тусгуулахаар НХОХХ болон ЭХЯ-д хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн ЭЗН-ийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Гадаадын тодорхойгүй эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан. ➤ “МЕСЕС” ХХК нь эхний ээлжинд өөрийн хөрөнгөөр 7,3 км ЦДӨХАШ-ыг барих бөгөөд 100% Паркийн эзэмшилд шилжүүлэх, гарсан нийт зардлын 50%-ийг ямар нэгэн нэмэгдэлгүйгээр Нийслэлийн төсвөөс шийдвэрлэх гэрээтэй ажиллаж байна. Энэ нь улсын төсөвт 2,2 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт бий болгоно. ➤ Мөн Мон-энержи Консалт ХХК-ийн гүйцэтгэж байгаа зураг төслийн ЦЭХ-ий хэсгийг энэхүү нөхцөлтэй уялдуулан шинэчлэн боловсруулах таатай боломж нээгдсэн учраас дэд бүтцийн ерөнхий зардлыг ихээхэн хэмжээгээр бууруулан байгуулах шийдэл гарч байгаа нь маш ач холбогдолтой арга хэмжээ болсон. ➤ “МЕСЕС” ХХК нь трассын дагуу геологийн шинжилгээний ажлыг эхлүүлсэн. ➤ БҮТП ОНӨТҮГ-аас хариуцах хөрөнгө оруулалтыг нийслэлийн төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх санал төслийг НЗД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батбаясгалан-д холбогдох материалуудын хамт 2020.08.26-ны өдрийн 154 тоот албан бичгээр хүргүүлээд байна.
3.1.д.	<p>Паркад шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч санаачлагатай ажиллах;</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Паркийн хөгжлийн Стратеги төлөвлөгөөний дагуу Паркад хөрөнгө оруулагчдыг татах боломжийг судлан, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлсэн. ➤ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор МУ-ыг хөгжүүлэх 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дэд бүтцийг байгуулах 108,7 тэрбум төгрөгийг баталсан ч санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй гэж заасан байв. ➤ 2019 оны 02 сард хөтөлбөрийн тодотголоор санхүүжилтийн саналаа тусгаж шийдвэрлүүлэхээр УУХҮЯ-ны ХҮГТГ, нийслэлийн ХБТГ болон Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. ➤ ҮХГ-аас 2019 онд МУ-д хөрөнгө оруулалт нэн тэргүүнд шаардлагатай 10 төслийг шалгаруулан баталсан бөгөөд тэдгээрийн жагсаалтад БҮТП-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт орсон. Гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарт саналуудыг хүргүүлэн ажилласан. ➤ Паркийн үйл ажиллагаанд хамтарч ажиллах хөрөнгө оруулагчдад чиглэсэн гадаад болон дотоодын нэгдсэн арга хэмжээнд оролцон бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Томоохон хэсгүүдээс дурдвал: <ul style="list-style-type: none"> ○ БНХАУ-ын Бээжин хотноо Монголын Эдийн засгийн хамтын ажиллагаа нийгэмлэг, БНХАУ-ын “Аж үйлдвэрийн холбоо” нийгэмлэг болон БНХАУ дахь Монгол Улсын ЭСЯ хамтран “Нэг бүс ба нэг зам төслийн Монгол дахь боломж” сэдэвт хөрөнгө оруулагчдын форумыг 2018 оны 03 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулахад оролцож, Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн танилцуулга хийж, “Нэг бүс ба зам” төслийн хүрээнд хөрөнгө оруулагч түншүүдтэй холбоо тогтоон Хүнд үйлдвэрлэлийн болон

		<p>биотехнологийн салбарт хамтран ажиллах мөн Бээжин хотын эдийн засаг технологийн паркттай танилцаж туршлага судлан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> ○ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/780 дугаар захирамжийн дагуу БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөх хотод зохион байгуулагдсан “Монгол-Хятадын хөрөнгө оруулалтын форум”-д байгууллагын дарга оролцож, “БҮТП-ийн дэд бүтэц, бүтээн байгуулалт төсөл”-ийг танилцуулсан. ○ Байгууллагаас 2 мэргэжилтнийг Бүгд Найрамдах Буриад Улс-Монгол Улсын бизнес чуулганд 2018 оны 5 дугаар сард оролцуулсан. Тус чуулганы үеэр Буриадын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор, аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцан холбоо тогтоож, туршлага судалсан. Тухайлбал импортыг орлох эко тоглоом үйлдвэрлэдэг “Наран” ХХК-ийн туршлагаар ижил төстэй үйлдвэрийг паркад байгуулах санааг төсөлд тусгалаа. ○ Багануур дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Хөрөнгө оруулагчдын таатай орчин” бизнес уулзалтыг хамтран зохион байгуулж, паркад элсэх хүсэлтэй 10 компанийн төлөөллийг урьж оролцуулав. Мөн паркийн иж бүрэн танилцуулгыг Монгол-Англи, Монгол-Хятад хэл дээр бэлтгэв. “Монхимо” ХК-ийн бүтээгдэхүүн болон Уурхайн нүүрс дагалдах эрдсийг ашиглах судалгааны материал, биет үзүүлэнг, “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн төслүүдэд ААНБ, хувийн хэвшлийн оролцоог бий болгох нь” сэдэвт илтгэлийг тавив. ○ Зах зээлийн хөгжил дэвшил, дэлхийн инноваци, дэвшилтэт техник технологийн талаар танилцуулах “EXPO MONGOLIA” олон улсын үзэсгэлэн 2018 оны 10 дугаар сард зохион байгуулагдаж тус Парк нь хөрөнгө оруулагчдыг татах, паркийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагч, үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргэх зорилготойгоор оролцсон. ○ Байгууллагын цахим хуудсаар хөрөнгө оруулагч нарт зориулсан “Хөрөнгө оруулъя - Хамтран ажиллая - Хамтдаа хөгжье” уриалга дэвшүүлсэн. ○ Гурав дахь удаагийн “Монгол – Хятадын экспо”-ийн хүрээнд зохион байгуулагдах “Бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-д оролцохоор төслийн маягыг НШУҮИГ-аар дамжуулан ҮХГ-т хүргүүлсэн. <p>➤ Үндэсний хөгжлийн газарт зохион байгуулагдсан, Хятадын хөрөнгө оруулагч компаниудад Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төсөл, нүүрс гүн боловсруулах чиглэлийн төслүүд болон Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг танилцуулж, үйл ажиллагаанд амжилттай оролцсон.</p> <p>➤ 2019.06.28-нд Улаанбаатар эдийн засаг 2019 форумд Газрын дарга, Хуулийн зөвлөх нар оролцсон.</p>
--	--	--

		<ul style="list-style-type: none"> ➤ Парк нь цахилгаан хангамжийн өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийг Нийслэлийн 2021 оны төсөвт суулгах тухай саналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2020 оны 01 дүгээр сарын 24-нд 15 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. ➤ Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилтийг боловсруулж дараах газруудад хүргүүлсэн. Үүнд: ➤ Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол, зургийн ажлын 2019 оны ажлын гүйцэтгэл, ТЭЗҮ, ТЭЗҮС, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний тайлбар зэрэг шаардлагатай бусад материалын хамт 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 24 дугаартай албан бичгээр, Улс, нийслэлийн төсөв болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын саналд, ➤ Монгол улсын 2021 оны төсвийн төсөлд тусгах “Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-ийн жагсаалтад, ➤ БХБЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ, Эрчим хүчний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны хөрөнгө оруулалтад, ➤ Нийслэлийг 2021-2025 он хүртэлх хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хотын хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний төсөлд, ➤ БҮТП-ийн ХЕТ болон инженерийн дэд бүтцийн зураг төслийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг 2020-2025 онд хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын нарийвчилсан тооцоолол хийж НХБТХ болон НШУҮИГ-аар уламжлан СЯ-нд, ➤ Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгах саналыг УУХҮЯ-нд, ➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн №03/3559 дугаартай албан бичгийн дагуу Улс, нийслэлийн төсөв болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын саналд, тус тус тусгасан. ➤ Паркийн цахилгаан хангамжийн 110/35/10 кВ-ын 7,3 км цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугамыг 2020 онд хэрэгжүүлэх боломжтой байгаа тул бүтээн байгуулалтын санхүүжилттэй холбоотой асуудлыг 2020.06.03-ны өдөр Нийслэлийн Засаг даргад 102, дүүргийн Засаг даргад 100, 2020.08.26-ны өдөр НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батбаясгалан, Улсын их хурлын гишүүн эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар, Улсын их хурлын гишүүн Ц.Сандаг- Очир, С.Амарсайхан нарт 150-153, 2020.09.10-ны өдөр Эрчим хүчний сайд Н.Тавинбэхд 163, Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэнд 170 дугаартай албан бичгээр тус тус уламжлан санал хүргүүлсэн.
--	--	---

		<ul style="list-style-type: none"> ➤ НШУҮИГ-ын дарга Б.Мөнх-Оргилд 162 дугаартай албан бичгээр концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг 09 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. ➤ Паркийн өнөөгийн байдлын танилцуулга болон дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлүүлэх, Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгуулах асуудлыг Уул уурхай, Хүнд үйлдвэрлэлийн сайд Г. Ёндон-д 2020.09.23-ны өдрийн 171 дугаартай албан бичгээр уламжилсан. ➤ Монгол УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Л. Оюун-Эрдэнэ Багануур дүүрэгт 09 дүгээр сарын 25-ны өдөр ирж удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар паркийн удирдлага паркийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалт, статус, паркуудын асуудлыг төрийн бодлогоор яаж эрхлэх талаар санал дэвшүүлсэн. ➤ Барилга хот байгуулалтын яамны инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Мөнхбаатар, эрчим хүч хариуцсан инженер Бадамсүрэн нартай БХБЯ дээр уулзалт зохион байгуулж, 2021 онд паркийн дэд бүтэц болон нийтийн барилга байгууламжинд шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар танилцуулга хийж, яамны зүгээс бодлого төлөвлөлтийн газар, хөрөнгө оруулалтын газраараа дамжуулан судалж дахин ярилцахаар санал солилцсон. Мөн паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг захиалагч болон гүйцэтгэгч талаас яаралтай дуусгаж, холбогдох байгуулагуудын хяналт магадлангаар баталгаажуулж, хүлээлгэж өгөх талаар санал солилцож хүсэлт тавьсан. ➤ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батбаясгалан даргатай 10 дугаар сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж НЗД-ын зөвлөлийн хурлаар оруулах асуудлын талаар хэлэлцэж санал солилцсон. ➤ НЗДТГ-ын Нийслэлийн инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М. Халиунбатад паркийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын талаар 186 дугаартай албан бичгийг 10 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн. ➤ Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх тухай 11.03-ны 198, 11.05-ны 202 дугаартай албан бичгүүдийг нийслэлийн инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Ихбаярт хүргүүлсэн. ➤ БХБ-ын Сайд Б.Мөнхбаатар газрын дарга нарын хамт Багануур дүүрэгт 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр уулзалт зохион байгуулсан ба паркийн удирдлага Ч.Элбэгсайхан паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцэж, БХБЯ дээр уулзалт зохион байгуулахаар тохиролцсон боловч цаг үеийн нөхцөл байдлын улмаас түр хойшлогдоод байна. ➤ Паркийн анхан шатны суурь судалгааны хүрээнд БҮТП-ийг хөгжүүлэх, дэд бүтцийг байгуулах төслийн ТЭЗ-ийн урьдчилсан судалгаа, мастер төлөвлөгөө, ХХААЯ-ны захиалгаар “ШУТИС” болон “Мэргэшсэн инженерүүдийн нийгэмлэг” ТББ-ын түншлэл ТЭЗҮ зэрэг материалууд хийгдсэн.
--	--	---

		<ul style="list-style-type: none"> ➤ 2016 онд Паркийн үйлдвэрүүдийн техник, технологийн түвшний үнэлгээг “ОЛНО” ХХК-аар гүйцэтгүүлсэн. ➤ Байгууллагын бодлогын баримт бичгийн хүрээнд паркийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Угтвар ажлын төлөвлөгөө, Логистик төвийн суурь судалгаа, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Эко-хот төсөл зэргийг боловсруулан баталсан. ➤ Паркийн мэдээллийн санд дараах эх үүсвэрүүдийг судалж оруулав. Үүнд: ➤ Арт констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн “Багануур хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөлт”ийн зураг төсөл, ➤ Зүүн бүсэд хамаарах гурван аймгийн мал аж ахуй, газар тариалангийн чиглэлийн нөөцийн судалгаа, ➤ Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр сум, Хэнтий аймгийн Батширээт сумын ойн сан болон цэвэрлэгээ хийх шаардлагатай талбайн нөөцийн хэмжээ, ➤ Ашигт малтмал газрын тосны газрын зөвшөөрлөөр Багануур дүүрэг, Төв аймгийн Мөнгөнморьт, Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршлын зураг болон бусад мэдээлэл, ➤ Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн 100 га газарт “Гранд–Амур” ХХК-ийн Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолын дагуу “WGS-84” солбицол, “UTM” тусгал, 1:500 масштабтайгаар гүйцэтгэсэн байр зүйн зураглал, ➤ ҮТП-ийн эзэмшил 414,0 га талбайг Нийслэл, Дүүргийн газрын албаны дэвсгэр зурагт тусгаж мэдээллийн нэгдсэн санд бүртгэв. ➤ Байгаль цаг уурын онцлогийн судалгааг бэлтгэх, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт гаргуулах хүрээнд Паркийн газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг Гранд-Амур ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлж 2018.06.07-ны өдөр актаар хүлээн авсан. ➤ БОАЖЯ-ны шинэчилсэн зааврын дагуу 2018 оны 12 дугаар сард “САТУ” ХХК нь Байгаль орчны төлөв байдлын урьдчилсан судалгааны ажлыг гүйцэтгүүлж, 2019 оны 02 дугаар сард хүлээн авсан. ➤ Нийслэлийн Засаг даргын 2019.06.21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар паркад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл хийлгэх 65 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр нарийвчилсан үнэлгээг “Санни трейд” ХХК-аар гүйцэтгүүлэн 2020.02.03-ны өдөр, барилгын зураг төслийг “Нутаг консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлж 2020.07.20-ны өдөр актаар хүлээн авсан. ➤ 2020 оны 03 сарын 04-ний өдөр цэвэрлэх байгууламжийн лагийг бордоо болгон үйлдвэрлэх технологийн мэдээллийг “Эко Тайхи” ХХК-ий менежер Ш.Болдсайхан-аас авч, хог хаягдлаар бордоо үйлдвэрлэдэг технологитой хоршуулах боломжийн талаар санал солилцов.
--	--	--

3.1.е.	Паркийн нэгжүүдийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг тогтоох, шалгуурт нийцсэн аж ахуйн нэгжийг бүртгэх;	<ul style="list-style-type: none"> ➤ Паркад үйлдвэр байгуулах хүсэлтэй дараах байгууллагуудын мэдээллийг хүлээн авч паркийн эрх зүйн байдал, эзэмшил газар, дэд бүтцийн нөхцөлийн талаар санал солилцож, зөвлөгөө өгөв. Үүнд: ➤ БҮТП-ийн нано-биотехнологийн бүсэд ШУТ-ийн “Монхимо” ХХК-ийн “Адуу” брэндийн төслийг инновацижуулах төслийг хүлээн авч 10,7 га газарт эрдэм шинжилгээ судалгаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх газрыг олгож нэгжийн гэрээ байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн. <ul style="list-style-type: none"> - Хүнд үйлдвэрийн бүсэд “Монгол шингэн нүүрс” ХХК-аас Герман улсын “Альфакат” технологийг инновацижуулан Багануурын хүрэн нүүрсийг гүн боловсруулж Евро-5 дизель түлш, битум хар тос, цэвэр ус гаргах байгаль орчинд халгүй “Нүүрснээс түлш үйлдвэрлэх КДВ 5000” төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авч, судалгаа дүгнэлт хийсний үндсэн дээр Паркийн нэгжээр гэрээ байгуулан, нефть боловсруулах тусгай зөвшөөрөл олгуулах саналыг 2017 онд УУХҮЯ-нд хүргүүлсэн. - Хөнгөн үйлдвэрийн бүсэд Япон улсын хөрөнгө оруулалтаар Шинэ Зеланд улсын “Ноос ноолуур гүн боловсруулах” өндөр хүчин чадлын эко үйлдвэрийн төслийг хүлээн авсан. Энэхүү үйлдвэр баригдсанаар ээрмэл утас, даавуу, оёдлын үйлдвэрүүд, хивс гар нэхмэлийн үйлдвэрүүд, техникийн болон барилгын дулаалгын материалын үйлдвэрүүд бий болох стратеги төлөвлөгөө хэрэгжинэ. - Паркад нэгжээр элсэх хүсэлт гаргасан “Санлюкс” ХХК-ийн “Органик нийлмэл бордоо” төслийг хүлээн авч, судалгаа хийж дүгнэлт гаргасан. - Паркад нэгжээр элсэх хүсэлт гаргасан “Монор-Улз” ХХК-ий “Эмийн ургамлын үйлдвэр, судалгааны төв” төслийг хүлээн авч, судалгаа хийж дүгнэлт гаргасан. - ШУҮ-ийн “Монхимо” ХХК-ийн Солонгос улсын эрдэмтэдтэй хамтран хийж байгаа “Утаагүй нүүрс” төслийг хүлээн авч судалгаа хийж хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гаргалаа. Хөрөнгө оруулалтын асуудал нь тодорхой болмогц газар ашиглуулах гэрээ хийж үйл ажиллагааг дэмжин эхлүүлнэ. - “Багануур сүү” ХХК-аас Сүү, Сүүн бүтээгдэхүүн болон Европ стандартын бяслаг үйлдвэрлэх төслийг хүлээн авч судалсан. - Нүүрсний химийн үйлдвэрийг байгуулах “Синкопа Монгол” ХХК - Багануурын уурхайн нүүрсээр тэсэлгээний бодис үйлдвэрлэх “Очир Ундраа” ХХК - Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хемп Монгол” ХХК - Казахстан улсын “Эрдэс баялгийг иж бүрэн боловсруулах үндэсний төв” болон “Эко импаст” ХХК-ийн удирдлагаас Багануурын уурхайн нүүрс, шорооны хаягдлаас цахиурт хөнгөн агааны хольц үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлэх боломж байгаа талаар дүүргийн болон паркийн удирдлагад танилцуулав. Дараа нь уурхайн үйл ажиллагаатай
--------	---	---

		<p>танилцуулж, нүүрсний шинж чанарын талаар мэдээлэл болон судалгааны зориулалтаар нүүрс шорооны холимгийн дээжийг авах ажлыг зохион байгуулав.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Мөн “Монгол Минерал” ХХК, түүний түнш Герман улсын “PHARMAWERK” компанийн удирдлагуудад паркийн үйл ажиллагааг танилцуулан исэлдсэн нүүрсний гуминыг хүн болон мал эмнэлгийн эмчилгээнд ашиглах чиглэл, түүний нөөцийн асуудлаар санал солилцож Багануурын нүүрсний уурхай үйл ажиллагааг танилцуулав. ➤ Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулах боломжтой Нүүрс хийжүүлэх технологийг суурин газарт нэвтрүүлэх төсөлтэй танилцаж дүгнэлт гаргасан. Нүүрс хийжүүлэх технологийг нэвтрүүлснээр түлшийг хэмнээд зогсохгүй экологи байгаль орчны бохирдлоос үүдэн гарах хүн амын эрүүл мэндэд үзүүлдэг сөрөг нөлөөлөл багасч, сум суурин газрын айл өрх байнгын халаалтын горимд шилжиж, утаагүй эко технологи нутагших боломж бүрдэнэ. ➤ Одоогоор Паркийн хуульд тусгагдсан нэгжүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан шинэ төслүүд хүлээн аваагүй байна.
3.1.ё.	Паркийн захиргааны байрны түрээс болон ашиглалтын зардлыг хариуцаж ажиллах;	Байгууллагын 2020 оны үйл ажиллагааны төсвөөс жилийн эцсийн байдлаар 26,6 сая төгрөгийг захиргааны байрны түрээс, ашиглалтын зардалд зарцуулсан.
3.1.ж.	Паркийн газар ашиглалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, эзэмшиж буй газрыг зориулалтын бусаар ашиглуулахгүй байх; /хөгжлийн төлөвлөгөөнөөс өөр зориулалтаар ашиглах болон бусдад дамжуулан түрээслүүлэхийг хориглох бөгөөд Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолыг баримтлах/	<ul style="list-style-type: none"> ➤ Паркийн эзэмшил 414 га газарт 2018 онд суурилуулсан 54 эргэлтийн цэгт хяналт тавин ажиллалаа. ➤ Багануур дүүргийн 3 дугаар хорооны Үйлдвэрийн хэсэгт байрлах паркийн хөнгөн үйлдвэрийн бүсийн 100 га газар дээгүүр Багануур Повер ХХК нь 2017.09 сард 931,8 м бохирын далд шугамыг зөвшөөрөлгүй тавьсан нь паркийн төлөвлөлт, газар зохион байгуулалтыг ноцтой зөрчсөн тул 2017.10 сард бохирын далд шугам хоолойг буцаан авахуулсан. 2018 онд тус газарт нөхөн сэргээлт хийгээгүй тул паркаас 2019 оны 57 дугаартай албан бичгээр 2019.05.10-ны дотор нөхөн сэргээлт хийх шаардлагыг тавьж Багануур Повер ХХК-аар 931,8 м газарт техникийн нөхөн сэргээлт хийлгэж 2019.05.14-нд актаар хүлээлцсэн. ➤ Нэг бүсэд Багануур ХК-ийн уурхайн эзэмшил газартай давхцал үүссэн болон бүсүүдийн зориулалт, багтаамжаас хамааруулж ургамал нанобиотехнологи, хүнсний үйлдвэрлэлийн бүсүүдийн нэршлийг өөрчилсөн учир газрын гэрчилгээг нийслэлийн Газар зохион байгуулалтын газраар шинэчилж гаргуулав. ➤ “Монхимо” ХХК-д Багануур дүүргийн Засаг даргын захирамжаар 10,7 га талбайд үйл ажиллагаа явуулах газар ашиглуулах гэрээ байгуулан ажиллаж байна.
3.1.з.	Паркийн бүсэд 2-оос доошгүй үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх;	<ul style="list-style-type: none"> ➤ БҮТП-ийн анхны нэгж ШҮҮ-ийн “Монхимо” ХХК-ийн “Адуу” брэндийн төслийн үйл ажиллагааг эхлүүлж өнөөдрийн байдлаар нанобиотехнологийн үйлдвэрлэл жигдэрч, дотоодын зах зээлд бүтээгдэхүүнээ тогтвортой боловч үйлдвэрлэлийн хүчин чадлаас хамаарч бага хэмжээтэй нийлүүлэн, БНСУ-д экспортолж байна.

		<ul style="list-style-type: none"> ➤ 2019 онд дэд бүтцийн зураг төсөл дуусаагүй, түүнийг барих хөрөнгийн асуудал шийдэгдээгүйгээс “И Пи Эм” ХХК-ийн барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор барих төслийг хүлээн авах, ургамал нанобиотехнологийн үйлдвэрлэлийн бүсийн хамгаалалтын хашаажуулалт, ойн зурвас, усжуулалтын системийг байгуулах ажил хойшлогдоод байна. ➤ Тус паркад нэгжийн гэрээ байгуулсан Нүүрс гүн боловсруулах үйлдвэр, санамж бичиг байгуулан ажиллаж байсан Ноос гүн боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа нь БҮТП-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалан хойшлогдоод байна. ➤ Хүнд үйлдвэрийн бүсэд дэд бүтэц байхгүй учраас төслүүдийг хүлээн авах боломжгүй байна.
3.1.и.	Паркийн үйл ажиллагааны явцыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тайлагнах;	Паркийн үйл ажиллагааны явцын тайланг жил бүр яаманд тогтоосон хугацаанд хүргүүлж байна.
3.2.	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2.2, Засгийн газраас баталсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-д заасан нөхцөлийг паркийн удирдлага бүрэн хангаж ажиллана.	<ul style="list-style-type: none"> ➤ БҮТП-ийн Хөгжлийн төлөвлөгөө болон “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-д заасан нөхцөлийг Паркийн удирдлага бүрэн ханган ажилласан. ➤ Паркийн техник, технологийн түвшний үнэлгээ 2016 онд “ОЛНОО” ХХК-аар гүйцэтгүүлсэн бөгөөд журмын дагуу шинээр хийлгэх хугацаа нь болсон боловч дараах шалтгаануудаас хамааран хийлгээгүй байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Паркад шинээр үйлдвэр байгуулагдаагүй байгаа • Нийслэлийн 2018, 2019 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үнэлгээ гүйцэтгүүлэх 30 сая төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй байна. ➤ Экспортын болон импортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд Паркийн нэгж “Монхимо” ХХК-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Тус компани нь байгаль орчинд халгүй дэвшилтэт нанотехнологиор хүний эрүүл мэндэд чиглэсэн Адуу брэндийн цуврал /Малын гаралтай биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 10 нэр төрлийн 59мян.350фл бүтээгдэхүүн, Ариутгалын бодис, эмийн 31 нэр төрлийн 959мян.фл бүтээгдэхүүн/-үүдийг үйлдвэрлэж, дотоодын зах зээлд гаргахаас гадна Солонгос, ОХУ-ын зах зээлд нэвтрүүлж эхэлсэн. <ul style="list-style-type: none"> - Паркийн нэгж “Монхимо” ХХК-ийн үйл ажиллагааг НЗД-д биечлэн танилцуулан, Ковид-19 цар тахлын хүнд үед хүн ам болон эмнэлгийн байгууллагуудыг шаардлагатай ариутгал, эрүүл ахуйн бүтээгдэхүүнээр тогтвортой тасралтгүй ханган ажиллахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. - Паркийн зүгээс Ерөнхий сайд болон салбарын сайдуудыг Багануур дүүрэгт ажиллах хугацаанд “Монхимо” ХХК-ийн “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-ийн хүрээнд батлагдсан

		<p>“Адуу” брэндийн үйлдвэрлэлийн өргөтгөлд шаардлагатай 5,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар хүсэлт тавьсан.</p> <ul style="list-style-type: none"> - Мөн компанийн малын дайвар бүтээгдэхүүнээс Гэрийн тэжээвэр амьтдын тэжээлийн үйлдвэрийн төслийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн. ➤ Дүүрэг, бүс нутгийн түүхий эдэд суурилсан инновацийн төслүүдийг хэрэгжүүлж импорт, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох зорилгоор Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах, зүлгүүр хийх үйлдвэр, Багануур цахилгаан механикийн үйлдвэрээс гарах төмрийн хаягдал хэрчдэсээр бэлэг дурсгалын зүйл хийх үйлдвэр, Хүүхдийн модон тоглоомын үйлдвэрийн төслүүдийг боловсруулж Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон Герман улсын GIZ ЭТИС хөтөлбөр хамтран зохион байгуулсан “Инноваци 2019” уралдаанд оролцож үндсэн шалгаруулалтад тэнцсэн. ➤ БСШУЯ-наас Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах төслийн саналыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэж, Азийн хөгжлийн банкнаас паркийн газар сонгох ажлын хэсгийн бүрэлдэхүүн 6 сард, газрын асуудал хариуцсан зөвлөх Пүрэвсүрэн, Табанакат болон газар өмчлөлийн ажлын хэсгийн Олон улсын байгаль орчны зөвлөх, эксперт Жон Картер болон Гансүх нарыг 10 сард тус тус хүлээн авч, паркийн үйл ажиллагааг дэлгэрэнгүй танилцуулав. Судалгааны багийн нэгдсэн дүнгээр бусад 5 байршлаас хамгийн боломжтой нь Багануур парк гэж гарсан. ➤ Олон улсын хамтын ажиллагааны КОЙКА байгууллагын төр хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрт тусгуулах инновацийн 2 төслийн саналыг боловсруулж 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаартай албан бичгээр хүргүүлэв.
3.3.	<p>Паркийн удирдлага нь гэрээний хавсралтад заагдсан аж ахуйн нэгжийн удирдлагатай гэрээ байгуулж, хөгжлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, паркийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана. Паркийн нэгжийг шинээр элсүүлэх тохиолдол бүрт гэрээний хавсралтад нэмэлтээр оруулна.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Одоогоор шинээр нэгж байгууллагыг элсүүлээгүй нь паркийн дэд бүтэц баригдаж ашиглалтад ороогүй байгаатай холбоотой байна.
3.4.	<p>Гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн эцэст гэрээ байгуулсан</p>	<p>Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны Сайдтай “Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын даргын 4 жилийн хугацаатай байгуулсан гэрээний дагуу 2017-2020 оны тайланг 3 дугаар улирлын байдлаар гаргаж 2020.09.23-ны өдрийн 171 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>

	төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, гэрээг дүгнүүлнэ.	
3.5.	Паркийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан журам, заавар, Монгол Улсын болон олон улсын стандартыг мөрдөн ажиллана.	<p>БҮТП нь дараах эрх зүйн үндсэн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль - Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж хөгжүүлэх үндсэн чиглэл - Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хяналт тавих журам - Татварын багц хуулиуд - Засгийн газрын Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл - Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэгжүүлэх журам, дүрэм - Бусад холбогдох хууль тогтоомж, журам - Паркийн үйл ажиллагаанд Монгол улсын болон ОУ-ын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна. <p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газраар хэлэлцэгдэн, дэмжигдсэнээр УИХ-аар хэлэлцүүлэхээр болж байгаа бөгөөд энэ хууль батлагдан гарснаар дагалдах Төрийн захиргааны байгууллагуудаас гарах журам, тогтоолууд шинэчлэгдэн гарах юм. Хууль шинэчлэгдэн батлагдсанаар Паркийн үйл ажиллагаанд тодорхой ахиц дэвшил гарах төдийгүй Нэгжүүдийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, эдийн засгийн үр дүнд илүү тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой.</p>
<p>Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн бусад ажлууд</p>		<ul style="list-style-type: none"> ➢ Парк нь 2017 оны 12 дугаар сард батлагдсан Паркийн хөгжлийн Стратеги төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2019 оноос эхлэн Паркийн удирдлага засаглалыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд <Парк инновацич байгууллага> болох зорилгыг хэрэгжүүлэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. ➢ БҮТП-ийн үйл ажиллагааг Нийслэл болон ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны аж үйлдвэржилтийн бодлогын зорилго зорилтууд, Алсын хараа-2050, Монгол Улсыг 2030 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал, Засгийн газрын “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэгт нийцүүлэх, дээд шатны байгууллагуудтай нягт хамтран уялдаа холбоотой ажиллах нь чухал шаардлагатай учир салбарын яамдтай 8, 10 дугаар сард /ХХААХҮЯ, БОАЖЯ, БШУЯ/ уулзалт зөвлөгөөн зохион байгуулан санал солилцож тодорхой чиглэлийг аван ажиллаж байна. ➢ Мөн холбогдох Элчин сайдын яамдтай зохион байгуулах уулзалтын санал, Нийслэлийн Засаг даргын хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг бэлтгэн НШУҮИГ-т 09 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. ➢ Паркийн харилцаа хамтын ажиллагаа, холбогдох чиг үүргийн хүрээнд НШУҮИГ, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, ДБҮҮХ, Боловсролын хэлтэс, ЗАА, МСҮТ, ЖДҮДТ,

	<p>Багануур тохижилт зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан. Мөн 2017 онд Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимд гишүүнээр элсэж, хамтын ажиллагааны гэрээ байгуулан холбогдох чиг үүргийн хүрээнд сургалт хөтөлбөрт оролцож, ХОФ-дад танилцуулга тогтмол хийж байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмын 3.4 /Паркийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрдэм шинжилгээ судалгаа явуулах нэгж, технологийн инкубатор төв байгуулах/ дэх заалтын дагуу ХААИС, Ургамал хамгааллын эрдэм, шинжилгээний хүрээлэн, ШУТИС, Шинэ АУИС, МУИС-уудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан төлөвлөгөөтэй ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> - 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр ШУТИС, ХААИС, ШАУИС, УХЭШХ-д хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлж, ЗГ-ын 30 тогтоолын хэрэгжилтийг ханган хамтран дүгнэх ажлыг цахимаар зохион байгуулсан. - Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хийгдэх зарим төлөвлөгөөт үйл ажиллагаанууд корона вирусийн цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. - 01 дүгээр сарын 09-ний өдөр МУИС-ийн 10 төлөөлөгч эрдэмтэн багш нарыг хүлээн авч, хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөг баталж, Багануур ХК-ийн үйл ажиллагаатай танилцуулав. - Дээрх их дээд сургуулиудтай гэрээ, санамж бичгийн хүрээнд байгуулсан төлөвлөгөөний 2020 оны биелэлтийг хүргүүлэхээр бэлтгэж байна. ➤ 2008 онд Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зориулалтаар Үйлдвэр худалдааны яамнаас, конторын барилгыг 1067 м.кв газрын хамт худалдан авсан уг барилгыг УИХ-ын 2018 оны 61 дүгээр тогтоолоор УУХҮЯ-наас нийслэлийн өмчид шилжүүлсэн бөгөөд 2019.12.13-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/1309 дугаар захирамжаар БҮТП-д хүлээлгэн өгч, Паркийн даргын 2019 оны 12 сарын 23-ны өдрийн А/38 тушаалаар 175,0 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгэн хүлээж авсан. <ul style="list-style-type: none"> - Энэхүү конторын барилга нь хүнсний үйлдвэрийн зориулалттай, олон жил ашиглалт хамгаалалтгүй байснаас хуучирсан, их хэмжээний засвар шаардлагатай болсон байсан. Паркийн удирдлага уг барилгыг засварлан, Эрдэм шинжилгээ судалгааны инкубатор, инновацийн төв /ЭШСИИТ/-ийг байгуулахаар төслийг боловсруулж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Эхний ээлжид уг барилгын тал хэсгийг шилжүүлэн авах, түүний засварын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. ➤ БҮТП-д Биотехнологийг хөгжүүлэх нь уриан дор 2017 онд 1, 2018 онд 4 удаа, 2019 онд 2 нийт 7 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөнийг дүүргийн үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан амжилттай зохион байгуулж, 2019 онд Хөх нуурын био станц, Хэрлэн баян улааны
--	--

	<p>ховор эмийн ургамлын плантацитай танилцаж туршлага судлав. Тус арга хэмжээнд ХААИС, ШАУИС, УХЭШХ болон ШУУ-ийн Монхимо ХХК-иудын төлөөллүүд эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар илтгэл тавьж оролцсон.</p> <p>- 2020 онд зохион байгуулахаар төлөвлөсөн уулзалт зөвлөгөөн болон нээлттэй өдөрлөг Ковид-19 цар тахалтай холбоотойгоор тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.</p> <p>➤ 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост бордоог “Багануур тохижилт” байгууллагын төв магистраль авто зам дагуух хамгаалалтын зурвасын модны тариалалтад ашигласан. Ургалтын явцад улирал тутам хяналт тавьж ажилласан.</p> <p>➤ Парк нь Багануурыг Биотехнологи эрчимтэй хөгжсөн хот болгох болон дүүргээ Эко-Хот болгох зорилтын хүрээнд хог хаягдлыг бууруулах, ашиглах чиглэлээр Багануур дүүргийн 5 хороод, 21 ААНБ-уудын 460 гаруй ажилчдад паркийн инженерүүдийн боловсруулсан ахуйн болон үйлдвэрийн хог хаягдалыг ашиглан компост бордоо хийх сургалтыг зохион байгуулахдаа БҮТП-ийн тухай ойлголт, үндсэн зорилтуудыг танилцуулах стратегитэй ажлууд маань нь маш үр дүнтэй арга хэмжээ болсон.</p> <p>➤ 2018-2019 онуудад үзүүлэх сургалт хийсэн 9 айл өрхийн компост бордоог 2020 оны 05, 10 дугаар саруудад газар дээр нь үзэж танилцан, зөвлөгөө өгч ажилласан.</p>
--	---

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА